



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 624

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 166,363,635.00 (нэг зуун жаран зургаан сая гурван зуун жаран гурван мянга зургаан зуун гучин таван) төгрөгийн балансын үнэ, 153,439,767.02 (нэг зуун тавин гурван сая дөрвөн зуун гучин есөн мянга долоон зуун жаран долоон төгрөг хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компани, “Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярсайхан, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, “Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн захирал Ч.Цогоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоож санхүүгийн тайланд тусгах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001072

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны дугаар сарын 7-ны өдрийн 684 дугаар тогтоолын хавсралт

"УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн этгээд
1	Автобус Хьюндай Аеро Сити, 44-89 УНУ, КМJTG18BPPBC009376	2011/2011	128,500,000.00	128,500,000.00	-	"Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" ТӨХК
2	Фургон УАЗ2206, 01-42 УНБ, 90496969	2009/2009	16,500,000.00	12,652,204.72	3,847,795.28	"Хөвсгөл дулааны" станц ТӨХК
	Фургон УАЗ220692-33, 25-94 УНӨ, 374100C0469241	2011/2012	21,363,635.00	12,287,562.30	9,076,072.70	"Хөвсгөл дулааны" станц ТӨХК
Нийт дүн			166,363,635.00	153,439,767.02	12,923,867.98	
			(нэг зуун жаран зургаан сая гурван зуун жаран гурван мянга зургаан зуун гучин таван)	(нэг зуун тавин гурван сая дөрвөн зуун гучин есөн мянга долоон зуун жаран долоон төгрөг хоёр мөнгө)	(арван хоёр сая есөн зуун хорин гурван мянга найман зуун жаран долоон төгрөг ерэн найман мөнгө)	